



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ**

2023 оны 09 сарын 21 өдөр

Дугаар 443

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг  
шинэчлэн тогтоож балансаас балансад  
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1, 5.6, 7.1, 7.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын Ерөнхий прокурорын газрын харьяа Тээврийн прокурорын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 23,000,000.00 (хорин гурван сая) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, үнийг 5,000,000.00 (таван сая) төгрөгөөр шинэчлэн тогтоож, хавсралтад заасны дагуу Налайх, Багахангай дүүргийн Прокурорын газарт балансаас балансад шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Улсын Ерөнхий прокурорын туслах прокурор, Хэрэг эрхлэх газрын дарга С.Гансэлэм, Тээврийн прокурорын газрын Тамгын хэлтсийн дарга С.Алимаа, Налайх Багахангай дүүргийн Прокурорын газрын Тамгын хэлтсийн дарга С.Анхбаяр нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх, хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Автомашиныг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж, хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл) түүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

137005927  
23-r\_huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2023 оны 09 дугаар сарын 01...өдрийн  
1/13 дугаар тогтоолын хавсралт

Тээврийн прокурорын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, үлдэх өртөггүй  
ашиглалтын хугацааг сунгаж, үнийг шинэчлэн тогтоож, балансаас балансад шилжүүлэх  
автомашинийн жагсаалт

д/д	Хөрөнгийн нэр	Үйлдвэрлэсэн/ ашиглалтад орсон он	Тоо хэмжээ	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл	Шинэчлэн тогтоох үнэ (төгрөг)	Цаашид ашиглах жил	Шилжүүлэн хүлээн авах байгууллага
1	Хьюндай Соната-7, улсын дугаар УБЗ-27-00 Арлын дугаар:	2014/2016	1	23,000,000.00	5,000,000.00	3	Налайх, Багахангай дүүргийн Прокурорын газар
Нийт дүн				23,000,000.00 (хорин гурван сая)	5,000,000.00 (таван сая)		